

**ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(Хараат бус аудиторын дүгнэлтийн хамт)

**УЛААНБААТАР ХОТ
2023 он**

Агуулга

Хуудас

Компанийн мэдээлэл	1
Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын батlamж мэдэгдэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3-5
Санхүүгийн Байдлын Тайлан	6
Ашиг, Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	7
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	8
Мөнгөн Гүйлгээний Тайлан	9
Санхүүгийн тайлангийн тодруулга	10-34

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Компанийн мэдээлэл

Компани байгуулах
тухай

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийг Засгийн Газрын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 407 дугаар тогтоолыг үндэслэн Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2017 оны 66 дугаар шийдвэрээр үүсгэн байгуулсан. Улсын бүртгэлийн албанад бүртгүүлсэнээр 6229697 тоот регистр бүхий 9011659117 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.
Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 241 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

Хувьцаа эзэмшигчид

Монгол Улсын Хөгжлийн банк 100 %

Албан ёсны хаяг

Монгол Улс, Улаанбаатар хот 14210,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайвны өргөн чөлөө -19, 12 давхар, 1214 тоот

Хараат бус аудитор

Гроут финанс аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот 14200,
Баянгол дүүрэг, 2-р хороо,
Амарсанаагийн гудамж,
Эрхи цогцолбор 603 тоот

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын батламж мэдэгдэл

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК (“Компани” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлалгын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Удирдлага нь энэхүү 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайланг тодруулга 2 ба 3-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвхөөр илэрхийлж чадах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мен удирдлага нь компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Удирдлага нь 6-аас 34 дүгээр хуудсанд илэрхийлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Компанийн удирдлагаас Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Д.Мөнхбат
Гүйцэтгэх захирал

С.Алтантуяа
Ерөнхий нягтлан бодогч

Монгол Улс,
Улаанбаатар хот

2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр



ГРУПТ ФИНАНС АУДИТ ХХК

Аудит нягтлан бодох бүртгэл, хөрөнгийн үзэлгээ, бизнесийн зөвлөгөө
Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,
Амарсанаагийн гудамж Эрхи цогцолборын 603 тоот
И-мэйл: info@growthfinance.mn, Утас: 976-9909 4391

“Ди Би Эм ассет менежмент
ҮЦК” ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчид

Огноо 2023. 4.21 Дугаар 02/11

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайланийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланда аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлантгуд нь “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид АОУС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлагаа хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Тасралтгүй байх зарчим

“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК нь “Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийн дундын санхүүжилтийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулахтай холбоотой баримт бичгийг боловсруулан Азийн хөгжлийн банкаар батлуулсан. Сангийн яамны зүгээс төслийн үнэлгээ хийж, эцсийн шийдвэр гарах хуртэл хугацаанд санг байгуулах хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлэх боломжгүй тухай мэдэгдсэн. Уг төсөл нь Монгол Улсын Засгийн газраас баримталж буй “Шинэ сэргэлтийн бодлого” чиглэлд тусгагдаагүй, хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтанд хамрагдаагүй,

төслийн хэрэгжилтийн явц хугацаа удаашралтай байгаа зэрэг нь төслийг цашид зогсоох эрсдэлтэй байна.

Мөн компанийн үүсгэн байгуулахаар шийдвэрлэж 2021 онд Санхүүгийн Зохицуулах хороонд бүртгүүлсэн Үндэсний стратегийн хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байна. Учир нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д Хөгжлийн банкнаас хөрөнгө оруулалтын санд хөрөнгө байршуулах шийдвэрийг Засгийн газар гаргахаар заасан боловч хэзээ шийдвэр гарах нь тодорхойгүй байна.

Бусад асуудал

Компанийн 2021 оны 12 сарын 31-нээрх дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайланд Үндэсний Аудитын газрын захиалгаар Грант Торnton аudit ХХК аudit хийж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын зохистой байх, авлагыг төлөгдөх боломжтой дүнгээр бүртгээгүй буюу СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрийн дагуу найдваргүй авлагын нөөц байгуулаагүй тул Хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна. Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны “Акт албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 392.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс татан буулгах комиссын ажилтнуудад 159.3 сая төгрөгийн цалин илүү олгосон зөрчилд төлбөрийн акт, түрээсийн талбайн хэмжээг жишиг нормоос хэтрүүлсэн 60.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, Чингис хаан банкнаас авах авлагын дунг шүүхийн шийдвэрийг үндэслэн бүртгээгүй 172.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хулээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цашид СТОУС гэх)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэг, хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайланг бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, тодруулах, шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хулээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан тайлан гаргах юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр тувшиний нотолгоо боловч АОУС-н дагуу хийгдсэн аudit нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлж байна гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг ба бид,

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, уг эрсдэлийг үнэлэн, эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж

өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиландаа хувалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландaa санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компани тасралтгүй байх зарчмийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүйд хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн ерөнхий тодруулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.



Групп Финанс Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Баянгол дүүрэг, 2-р хороо, Баруун 4 зам,
Эрхи цогцолбор 603 тоот
2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үсийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үсийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн Байдлын Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

(Төгрөгөөр)

	<i>Тодруулга</i>	2022.12.31	2021.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	2,163,134,396.10	10,077,796,463.80
Дансны болон бусад авлага	5	1,055,265,860.47	1,211,496,281.00
Татвар, шимтгэлийн авлага	6	14,351,765.82	14,375,886.16
Бусад санхүүгийн хөрөнгө	7	7,160,000,000.00	-
Бараа материал	8	167,909.09	90,000.00
		10,392,919,931.48	11,303,758,630.96
Эргэлтийн хөрөнгийн дүн			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	9	97,128,719.08	121,071,738.86
Биет бус хөрөнгө	10	555,376.94	4,287,640.55
		97,684,096.02	125,359,379.41
ХӨРӨНГИЙН ДҮН			
		10,490,604,027.50	11,429,118,010.37

ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Өр төлбөр

Дансны болон бусад өглөг	11	1,464,799,032.84	1,797,478,651.04
Татвар, шимтгэлийн өглөг	12	122,000.00	4,188,054.87
		1,464,921,032.84	1,801,666,705.91
Богино хугацаат өр төлбөрийн дүн			
Эздийн өмч			
Хувьцаат капитал	13	10,000,000,000.00	10,000,000,000.00
Хуримтлагдсан ашиг		(974,317,005.34)	(372,548,695.54)
		9,025,682,994.66	9,627,451,304.46
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН			
		10,490,604,027.50	11,429,118,010.37

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайллангийн салшгүй хэсэг болно.

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)	<i>Тодруулга</i>	2022	2021
Борлуулалтын орлого		-	-
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг		-	-
Ерөнхий удирдлагын зардал	14	(354,401,385.98)	(722,397,878.45)
Борлуулалт маркетингийн зардал		-	-
Үйл ажиллагааны ашиг		(354,401,385.98)	(722,397,878.45)
Санхүүгийн орлого	15	150,054,794.51	268,833,852.01
Санхүүгийн зардало		-	-
Бусад орлого	16	687,260.00	75,276,348.36
Бусад зардал	16	(383,103,498.87)	(2,196,914.04)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз, (гарз)		-	-
Татварын өмнөх ашиг		(586,762,830.34)	(380,484,592.12)
Орлогын албан татварын зардал	17	(15,005,479.46)	(26,883,385.22)
Тайлант жилийн цэвэр ашиг		(601,768,309.80)	(407,367,977.34)
Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй орлого			
Нэгж хувьцаанд ногдох ашиг	18	(12,035.37)	(8,147.36)

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайллангийн салшгүй хэсэг болно.

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

<i>(Төгрөгөөр)</i>	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт эзийн өмчийн дун
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000,000.00	34,819,281.80	10,034,819,281.80
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Залруулсан үлдэгдэл	10,000,000,000.00	34,819,281.80	10,034,819,281.80
Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)	-	(407,367,977.34)	(407,367,977.34)
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	10,000,000,000.00	(372,548,695.54)	9,627,451,304.46
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Залруулсан үлдэгдэл	10,000,000,000.00	(372,548,695.54)	9,627,451,304.46
Тайлант жилийн цэвэр ашиг	-	(601,768,309.80)	(601,768,309.80)
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	10,000,000,000.00	(974,317,005.34)	9,025,682,994.66

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Мөнгөн Гүйлгээний Тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого:

	2022.12.31	2021.12.31
Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого	10,216,188.67	8,417,130,126.29
Буцаан авсан албан татвар	-	346,164,518.08
Бусад мөнгөн орлого	9,605,506.85	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага:		
Ажиллагчдад төлсөн мөнгө	610,681.82	8,070,965,608.21
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	1,447,027,375.82	7,062,263,362.07
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	349,264,328.66	436,940,671.24
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	95,756,027.12	130,144,806.68
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	1,674,450.00	1,181,304.88
Төлсөн татвар	97,069,683.44	141,017,756.04
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	4,971,226.42	3,040,115.00
Бусад зардалд төлсөн мөнгө	239,588,614.11	60,408,237.53
	1,509,590.00	1,688,840.00
	<u>657,193,456.07</u>	<u>6,287,841,630.70</u>
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,436,811,187.15)	1,354,866,764.22

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Хүлээн авсан хүүний орлого	48,696,164.38	765,854,866.17
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан телелт	588,968,221.33	-
Бусад	-	5,999,990,000.00
Худалдан авсан үндсэн хөрөнгө	-	(4,523,000.00)
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	<u>(7,450,000,000.00)</u>	<u>-</u>
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(6,812,335,614.29)	6,761,321,866.17
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн зөрүү	334,484,733.74	(440,502.25)
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	334,484,733.74	(440,502.25)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(7,914,662,067.70)	8,115,748,128.14

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл

10,077,796,463.80	1,962,048,335.66
2,163,134,396.10	10,077,796,463.80

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

1. Компанийн ерөнхий мэдээлэл

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК нь 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдөр хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилгоор үүсгэн байгуулагдсан. Санхүүгийн Зохицуулах Хорооны 2017 оны 241 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх 360/16 тоот тусгай зөвшөөрөл авсан.

Засгийн Газрын 2020 оны 155 тоот тогтоолоор “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК болон сангудыг татан буулгаж, хөрөнгө, өр, авлага холбогдох бусад зүйлсийг Хөгжлийн банкинд шилжүүлэх шийдвэр гарсан.

Засгийн газрын 2021 оны 252 тоот тогтоолоор “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийг татан буулгах үйл ажиллагааг зогсоож, үйл ажиллагааг сэргээн хэвийн үргэлжлүүлэх шийдвэр гарсан. Тус шийдвэрийг үндэслэн Монгол Улсын Хөгжлийн банкны ТҮЗ-ийн 2021 оны 29 дүгээр тогтоолоор компанийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг МУХБ-ны гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлэхээр баталсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 8 дугаар шийдвэрээр компанийн дүрэм болон бүтцийг шинэчлэн баталсан.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 5 дугаар шийдвэрээр Үндэсний стратегийн хөрөнгө оруулалтын санг хувийн хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр үүсгэн байгуулахаар шийдвэрлэсний дагуу үүсгэн байгуулах баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 11 сарын 24-ний өдрийн 539 дүгээр тогтоолоор бүртгүүлсэн.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК нь Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөн, орлогод нийцсэн, хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадвартай, амьдрахад таатай эко хороолол болгон хөгжүүлэх зорилготой “Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төслийг 2019 оноос хэрэгжүүлэхээр Азийн Хөгжлийн Банк болон Улаанбаатар хотын захиргаатай хамтран ажиллаж байна.

2. Санхүүгийн тайлагналын зарчим

(1) Санхүүгийн тайлан бэлтгэхэд баримталсан стандарт

Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн.

(2) Үнэлгээний суурь

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

(3) Бүртгэлийн болон толилуулгын валют

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнахдаа компанийн бүртгэлийн валют бөгөөд компанийн үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн орчны гол валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд санхүүгийн тайланг төгрөгөөр толилуулсан.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

2. Санхүүгийн тайлагналын зарчим, Үргэлжлэл

(4) Таамаглал, тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Бодит үр дүн нь эдгээр таамаглал, тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ, тооцоолол түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөлөл нь байнга хянаж шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

(5) Тасралтгүй байх зарчим

Санхүүгийн тайлан нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах зарчимд үндэслэн бэлтгэгдсэн бөгөөд энэ нь компани ойрын үед хөрөнгөе үйл ажиллагаанд ашиглаж, өр төлбөрөө төлж, үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулна гэдгийг илэрхийлнэ.

Дүгнэлтийн хэсэгт дурдагдсанаас бусад зүйлсийн хувьд компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан гарсан өдрөөс хойш 12 сарын хугацаанд компани ирээдүйд гарах гэрээний төлбөрүүд болон бизнесийн явцад үүсч байдаг өр төлбөрүүдийг төлөх хангалттай хэмжээний эргэлтийн болон капиталын хөрөнгөтэй гэж үзэж байгаа.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

(1) Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусгавар хугацаа нь худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар болон түүнээс богино хугацаагаар тодорхойлогдсон бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөхөд өчүүхэн төдий эрсдэлийг мэдэрдэг, компанийн удирдлага богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшиж буй бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө (барыцаалсан хадгаламжийг оруулахгүй)-өөс бүрдэнэ.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр

Компани үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг дараах ангиллын дагуу ангилдаг. Үүнд: хотогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр (БДОБҮЦ) хэмжсэн санхүүгийн хөрөнгө болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр (ААБҮЦ) хэмжсэн санхүүгийн хөрөнгө зэрэг багтана. Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хотогдуулсан өртгөөр хэмжсэн болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг.

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр – хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани дансны авлага болон өрийн үнэт цаасыг анх үүссэн өдөр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх гэрээний нөхцөл компанийд хамааралтай болох тэр үед хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бараг бүгдийг нь шилжүүлсэн эсвэл шилжүүлэгүй боловч эрсдэл, өгөөжийг хадгалаагүй бөгөөд хяналтыг авч үлдээгүй бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа дуусгавар болсон үед санхүүгийн байдлын тайланд үл хүлээн зөвшөөрдөг. Компани нь санхүүгийн өр төлбөрийн нөхцөл өөрчлөгдөж, өөрчлөгдсөн өр төлбөрийн мөнгөн урсгал материаллаг хэмжээнд ялгаатай бөгөөд өөрчлөгдсөн нөхцөлд үндэслэн шинэ санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнөх санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрхөд дансны үнэ болон төлбөр барагдуулхад төлсөн дүн хоёрын зөрүүг ашиг, алдагдалаар хүлээн зөвшөөрдөг.

(ii) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө – хэмжилт

a) Хотогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангасан буюу (i) гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай (ii) гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэлд тооцогддог бол уг хөрөнгийг хотогдуулсан өртгөөр хэмжинэ.

Эдгээр санхүүгийн хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа тайлант үеүдэд үр ашигт хүүгийн арга ашиглан хотогдуулсан өртгөөр хэмжинэ. Хотогдуулсан өртөг нь үнэ цэнийн бууралтын алдагдлаар буурдаг. Хүүгийн орлого, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

b) Бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжсэн санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангасан буюу (i) гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай (ii) гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урстгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэл тооцогддог бол уг хөрөнгийг бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжсэн санхүүгийн хөрөнгөөр хэмжинэ.

Эдгээр санхүүгийн хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр хэмжинэ. Өрийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хүүгийн орлого, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад цэвэр олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө.

c) Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө

Дээр дурдсан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, эсвэл БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөөр гэж ангилагдаагүй бүх санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилна. Эдгээр санхүүгийн хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр хэмжинэ. Хүүгийн орлого, ногдол ашгийн орлого зэрэг багтсан цэвэр олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(iii) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр

Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр, эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэдэгт арилжаалах зориулалтаар эзэмших нөхцлийг хангасан эсвэл анх хүлээн зөвшөөрөх үед уг өр төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр нь тодорхойлсон байвал энэ ангиллын санхүүгийн өр төлбөрт хамааруулна.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр нь бодит үнэ цэнээрээ хэмжигдэх бөгөөд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрөөс бусад үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн өр төлбөрийн ангилалд хамааруулдаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмждэг ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хүүгийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад цэвэр олз, гарзыг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(iv) Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах нь

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тусгах, хууль, эрх зүйн үндэслэлтэй эсэх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

(3) Үнэ цэнийн бууралт

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө

Компани хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг (i) хорогдуулсан өргөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, (ii) БДОБУЦ-ээр хэмжсэн өрийн хөрөнгө оруулалт (iii) гэрээний хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрдөг. Компани алдагдлын санг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжсэн дараахаас бусад хөрөнгийн хувьд уг хөрөнгийн эзэмших эрх дуусах хүртэлх хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг хэмждэг. Үүнд:

- Тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон
- Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэхийг тодорхойлж, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг тооцохын тулд компани нь холбоотой бөгөөд аливаа нэмэлт зардал эсвэл хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломж бүхий үндэслэлтэй бөгөөд нотлогдохуйц мэдээллүүдийг харгалzan үздэг.

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн санхүүгийн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэхийг тодорхойлж, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг тооцохын тулд компани нь холбоотой бөгөөд аливаа нэмэлт зардал эсвэл хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломж бүхий үндэслэлтэй бөгөөд нотлогдохуйц мэдээллүүдийг харгалzan үздэг.

Үүнд Компанийн түүхэн мэдээлэлд үндэслэн чанарын болон тоон үзүүлэлтэнд шинжилгээ хийх, мэдээлсэн эрсдэлийн үнэлгээ болон ирээдүйн тоон мэдээлэл багтана.

Дансны авлага болон гэрээний хөрөнгийн хувьд алдагдлыг үргэлж гэрээний хугацаатай тэнцүү байхаар хүлээгдэж буй эрсдлийн алдагдалын санг хэмждэг.

Компани нь санхүүгийн хөрөнгийн эргэн төлөлтийн хугацаа 30 хоногоос хэтэрсэн тохиолдолд хүлээгдэж буй эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн гэж үздэг.

Компани нь санхүүгийн хөрөнгийг дараахаа нөхцөлд хугацаа хэтэрч, үүргээ биелүүлээгүй гэж үздэг:

- Компанид эргэн төлөх үүргээ бүрэн биелүүлж чадахгүй тохиолдолд; эсвэл
- Санхүүгийн хөрөнгө 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн

Компани нь санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог. Хөрөнгийг анх бүртгэнээс хойш алдагдалд хүргэх үйл явдал болсон бөгөөд уг үйл явдлын улмаас тухайн хөрөнгийн ирээдүйд бий болгох мөнгөн урсгал буурсан байвал уг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог харуулах дараах үйл явдлууд байна:

- Зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал нэлээд хэмжээгээр хүндэрсэн;
- 90 хоногоос дээш эргэн төлөх хугацаа хэтэрсэн эсвэл гэрээний үүргээ биелүүлэх чадваргүй болсон зэргээр гэрээний заалтыг зөрчсөн;
- Компанид өөр нөхцөл байхгүй байсантай холбоотой зээл болон урьдчилгаа төлбөрийн бүтцийг өөрчилсөн;
- Зээлдэгч нь дампуурал зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин зохион байгуулалт хийх магадлалтай;
- Санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болсон

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна.

БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн үнэт цаасын хувьд алдагдлын санг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайлан дахь санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна. БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн үнэт цаасын хувьд алдагдлын санг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайлан дахь санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй.

Компанийн санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөх хангалттай хүлээлт байхгүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг данснаас хасна.

(ii) Санхүүгийн бус хөрөнгө

Бараа материал болон хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад компанийн санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дунг тооцоолдог. Ашиглалтын хугацааг нь тодорхойлох боломжгүй эсвэл одоогоор ашиглагдах боломжгүй гүүдвилл болон биет бус хөрөнгийн нөхөгдөх дунг жил бүрийн ижил үед шалгадаг.

Компани бие даасан хөрөнгийн нөхөгдөх дунг тооцдог ба хэрэв хөрөнгийн бие даасан нөхөгдөх дунг тооцоолох боломжгүй бол компани хөрөнгөтэй хамааралтай мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дунг тодорхойлдог. Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгж гэдэг нь бусад хөрөнгө буюу хөрөнгийн бүлгээс орох мөнгөн орлогын урсгалаас ихээхэн хамааралтай мөнгөн орлогыг үүсгэдэг хөрөнгийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүн нь мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байдаг. Ашиглалтын үнэ цэнийг тооцоходоо хөрөнгийн хувьд онцлог эрсдэл болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээг ашиглан хөрөнгийг тасралтгүй ашиглалсаас болон ашиглагдахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгө эсвэл мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(4) Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлдэг. Түүхий эд, бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд авч ирэхтэй холбогдож гарсан бүх зардал багтдаг. Бараа материалын өртгийн дундаж өртгийн аргаар тодорхойлдог. Бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн өртөгт шууд материал, шууд хөдөлмөр, бусад шууд өртөг болон хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал орох бөгөөд зээлийн өртгийг оруулахгүй. Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардлагдах тооцсон зардлыг хассан дүнг хэлнэ.

(5) Үндсэн хөрөнгө

(i) Хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анх дансанд өртгөөр нь хэмжиж хүлээн зөвшөөрдөг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

(ii) Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараагаар үндсэн хөрөнгийн дансны үнэ нь түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Үндсэн хөрөнгийн зүйлсийг борлуулсанаас үссэн олз, гарзыг үндсэн хөрөнгийн дансны үнэ болон цэвэр борлуулалтын орлогын зөрүүгээр тодорхойлдог.

(iii) Дараа үеийн зардлууд

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

(iv) Элэгдэл

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг. Түрээсийн хөрөнгийн хувьд түрээслэгч нь түрээсийн хугацааны эцэст хөрөнгийн өмчлөлийн эрхийг авах нь тодорхой биш бол тухайн хөрөнгийг түрээсийн хугацаанд нь эсвэл түүнийг ашиглахаар тооцсон хугацааны аль богино хугацаагаар нь элэгдүүлдэг. Үндсэн хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон түүнтэй зэрэгцүүлэх хугацаанд тооцсон эдийн засгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

	Ашиглагдах жил
Машин, тоног төхөөрөмж	10
Тавилга эд хогшил	10
Компьютер, бусад хэрэгсэл	3
Бусад үндсэн хөрөнгө	10

Хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглахаар тооцсон хугацаа болон үлдэх өртгийг тайлант жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг.

(6) Биет бус хөрөнгө

(i) Хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй биет бус хөрөнгийн зүйлсийг анх дансанд өргөөр нь хэмжиж хүлээн зөвшөөрдөг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

(ii) Хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилт

Компанийн худалдан авсан тодорхой ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг түүний өртгөөс хууримтлуулсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр хэмждэг.

(iii) Дараа үеийн зардлууд

Дараа үеийн зардлыг зөвхөн холбогдох хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай үед капиталжуулдаг. Бусад бүх зардлыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(iv) Хорогдуулга

Биет бус хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар хорогдуулж, ашиг алдагдлаар зөвшөөрдөг. Биет бус хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон түүнтэй зэрэгцүүлэх хугацаанд тооцсон эдийн засгийн ашиглах хугацаа дараах байдалтай байна.

Программ хангамж

Ашиглагдах хугацаа

3 жил

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. **Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл**

(7) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж, урамшуулал

(i) Тодорхой шимтгэл бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр

Хуулийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

(8) Гадаад валютаар хийгдсэн гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж, төгрөг валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөг руу хөрвүүлэн илэрхийлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар үйл ажиллагааны валют руу хөрвүүлэн илэрхийлдэг.

Борлуулах боломжтой өмчийн хэрэглүүрийн дахин хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүнээс бусад тохиолдолд гадаад валютын дахин хөрвүүлэлтийн ханшийн зөрүүг ашиг, алдагдаар хүлээн зөвшөөрч, санхүүгийн өр төлбөрийг гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалтын баталгаа болгон эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын тайланд мөнгөн урсгалын баталгаа болгон хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаарх түүхэн өргтгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

(9) Нөөц ба болзошгүй өр төлбөр

Компани нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй бол ирээдүйн мөнгөн зарлагын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан нөөцийн дүнг тодорхойлдог. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн өр төлбөртэй холбоотой эрсдлийн өнөөгийн зах зээлийн үнэлээмжийг тусгасан байх ёстой. Дискаунтыг буцааснаар үүсэх зардлыг санхүүгийн зардал гэж бүртгэдэг.

Эдийн засгийн өгөөжийг зарцуулах магадлал бага эсвэл зардлын дүнг найдвартай тооцоолох боломжгүй бол энэхүү үргийг болзошгүй өр төлбөр гэж тайлагнадаг. Эдийн засгийн өгөөжийг зарцуулах магадлал маш бага бол болзошгүй өр төлбөр гэж үзэхгүй. Боломжит өр төлбөрүүд нь бодитой болох эсэх нь ирээдүйд нэг ба түүнээс дээш үйл явдлаас хамаарч байвал мөн болзошгүй өр төлбөрөөр тайлагнадаг. Эдийн засгийн өгөөжийг зарцуулах магадлал маш бага бол болзошгүй өр төлбөр гэж үзэхгүй.

**“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бodoх бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

(10) Хувьцаат капитал

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

Компани гаргасан хувьцаат капиталаа эргүүлэн худалдан авах үед төлөхөөр тооцсон дунг өмчийн хэсгийг бууруулан халаасны хувьцаа болгон бүртгэнэ. Халаасны хувьцааны худалдан авалт, борлуулалт, дахин гаргалт болон гүйлгээнээс гаргах үед үүссэн аливаа олз, гарзыг тайлант үеийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрдөггүй. Компани халаасны хувьцаагаа хадгалах эсвэл худалдан авах үед төлсөн эсвэл хүлээн авахаар тооцсон дунг өмчийн хэсэгт шууд хүлээн зөвшөөрнө.

(11) Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хүүгийн орлого ба ногдол ашгийн орлогоос бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг. Ногдол ашгийн орлогыг Компанид ногдол ашиг хүлээн авах эрх үүссэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Бүх төрлийн зээлийн хүүгийн зардлуудыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан орлогын тайланд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(12) Орлогын албан татвар

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдох орлогод тайлант жилийн эцсээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой болсон татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр, мөн өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой тохируулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлагналын болон татварын зорилгоор тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийн хооронд үүссэн түр зөрүүтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрдөг.

Тайлант жилийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээнд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, Үргэлжлэл

Компани тайлант жилийн болон хойшлогдсон татварын дүнг тодорхойлохдоо татвартай холбоотой тодорхойгүй нөхцөл байдал, нэмэлт татвар болон хүү төлөгдөх магадлал гэх мэт хүчин зүйлсийн нөлөөг тооцож үздэг. Татварын хууль тогтоомжийн тайлбар, өмнөх жилүүдийн туршлага гэх мэт олон хүчин зүйлсийг үнэлсэнд үндсэн дээр компани татварын өр төлбөрөө нээлттэй татварын жилүүдэд хангалттай хэмжээнд хуримтлуулсан гэж узэж байна.

Энэхүү үнэлгээ нь компанийн ирээдүйн үйл явдлын талаарх тооцоолол, таамаглал болон олон хувилбарт үнэлэмжинд үндэслэдэг. Одоогийн хуримтлуулсан татварын өр төлбөрийн хангалттай байдлын талаарх компанийн үнэлэмжинд нөлөө үзүүлж болохуйц шинэ мэдээлэл, нөхцөл байдал үүсч болох юм. Энэхүү нөлөө нь тухайн өр төлбөрийг тодорхойлсон тайлант хугацааны татварын зардалд нөлөөлнө.

Компани хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн цэвэр дүнг гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй бөгөөд түүнд ногдуулсан татварыг компанийг хариуцсан нэг татварын байгууллагаас ногдуулсан тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тайллагнаж болно.

Ашиглагдаагүй татварын алдагдал, хөнгөлөлт болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг тэдгээрийг ашиглаж болохуйц хэмжээний ирээдүйн татвар ногдох орлого олох нь магадлалтай хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант жилийн эцэс бүрт дахин хянаж үздэг. Хойшлогдсон татварын хөрөнгийн өгөөжийг ашиглах боломжтой хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох хэмжээгээр компани нь хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

(13) Холбоотой талууд

- (i) Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанийтай холбоотой гэж үзнэ:
 - Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг
 - Компанид мэдэгдэхуйц нөлөөлөлтэй
 - Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.
- (ii) Дараах нөхцлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгж компанийтай холбоотой гэж үзнэ:
 - Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группын бүрэлдэхүүнд багтаж байвал (өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанийд хамаардаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой);
 - Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол (эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан группын нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол);
 - Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
 - Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

- Тухайн аж ахуйн нэгж нь компани эсвэл түүнтэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжинд зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- (i)- тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж (эсвэл түүний толгой компанийн)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанийтай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
Касс дахь бэлэн мөнгө	184,818.84	1,025,613.06
Харилцах дахь мөнгөн хөрөнгө	2,012,949,577.26	10,076,770,850.74
Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө	150,000,000.00	-
Мөнгөн хөрөнгийн дүн	2,163,134,396.10	10,077,796,463.80

5. Дансны болон бусад авлага

Дансны болон бусад авлага нь дараах данс ангилалаас бүрдэж байна:

(Төгрөгөөр)

Дансны авлага

Менежментийн үйлчилгээний авлага

Дансны авлагын дүн

Бусад авлага

Хувь хүнээс авах авлага

159,300,000.00

Байгууллагаас авах авлага

769,369,879.33

791,308,951.66

Хүүгийн авлага

334,486,048.14

420,187,329.34

Ажиллагсаас авах авлага

3,233,021.21

3,109,021.21

Найдвартгүй авлагын хасагдуулга

(211,123,088.21)

(3,109,021.21)

Бусад авлагын дүн

Дансны болон бусад авлагын дүн

1,055,265,860.47

1,211,496,281.00

1,055,265,860.47

1,211,496,281.00

2022 оны 12-р сарын 31-нээрх авлагын дунд Шүүхийн шийдвэр гарсан Чингис хаан банкнаас авах авлага 962.3 сая төгрөг, өмнөх оны аудитын шалгалтаар илэрсэн зөрчилд тавьсан татан буулгах комиссын ажилчидтай холбоотой 159.3 сая төгрөгийн авлага, “Ти Би Групп” ХХК-аас авах түрээсийн байрны барьцааны маргаантай байгаа авлага 34.3 сая төгрөг эргэлзээтэй байна. Тайлант хугацаанд Чингис хаан банкнаас авах авлагын дунд 21.6 хувиар найдвартгүй авлагын хасагдуулга нэмж бүртгэсэн.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

6. Татвар шимтгэлийн авлага

Татвар шимтгэлийн авлага нь дараах данс ангилалаас бүрдэж байна:

(Төгрөгөөр)

	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
НӨАТ-ын авлага	14,038,599.15	4,453,758.09
НӨАТ-ын хойшлогдсон авлага	1,500.00	4,954.55
ААНОАТ-ын авлага	311,666.67	9,917,173.52
Татвар шимтгэлийн авлагын дүн	14,351,765.82	14,375,886.16

7. Бусад санхүүгийн хөрөнгө

Бусад санхүүгийн хөрөнгө дансны дүн дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
Хугацаат хадгаламж	350,000,000.00	-
Бонд	6,810,000,000.00	-
Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	7,160,000,000.00	-

8. Бараа материал

Бараа материал дансны дүн дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
Бичиг хэргийн материал	167,909.09	90,000.00
Бараа материалын дүн	167,909.09	90,000.00

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

9. Үндсэн хөрөнгө

(1) Үндсэн хөрөнгө дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

Өртөг

2022 оны 12-р сарын 31

	Өртөг	Хурилтлагдсан элэгдэл	Дансны үнэ
Тавилга эд хогшил	93,063,530.00	46,159,091.48	46,904,438.52
Компьютер, дагалдах хэрэгсэл	69,441,645.08	67,627,939.00	1,813,706.08
Тээврийн хэрэгсэл	122,239,012.85	75,573,353.27	46,665,659.58
Бусад үндсэн хөрөнгө	3,443,716.65	1,698,801.75	1,744,914.90
Дүн	288,187,904.58	191,059,185.50	97,128,719.08

(Төгрөгөөр)

Өртөг

2021 оны 12-р сарын 31

	Өртөг	Хурилтлагдсан элэгдэл	Дансны үнэ
Тавилга эд хогшил	93,063,530.00	36,858,340.16	56,205,189.84
Компьютер, дагалдах хэрэгсэл	69,441,645.08	63,902,736.70	5,538,908.38
Тээврийн хэрэгсэл	122,239,012.85	65,000,438.54	57,238,574.31
Бусад үндсэн хөрөнгө	3,443,716.65	1,354,650.32	2,089,066.33
Дүн	288,187,904.58	167,116,165.72	121,071,738.86

(2) Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

Өртөг

2022 оны 12-р сарын 31

	01 сарын 01 -ний улдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	12 сарын 31-ний улдэгдэл
Тавилга эд хогшил	93,063,530.00			93,063,530.00
Компьютер, дагалдах хэрэгсэл	69,441,645.08			69,441,645.08
Тээврийн хэрэгсэл	122,239,012.85			122,239,012.85
Бусад үндсэн хөрөнгө	3,443,716.65			3,443,716.65
Дүн	288,187,904.58	-	-	288,187,904.58

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

9. Үндсэн хөрөнгө, Үргэлжлэл

(Төгрөгөөр)

Өртөг

2021 оны 12-р сарын 31

	1 сарын 01 -ний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	12 сарын 31-ний үлдэгдэл
Тавилга эд хогшил	93,063,530.00		-	93,063,530.00
Компьютер, дагалдах хэрэгсэл	65,329,826.90	4,111,818.18	-	69,441,645.08
Тээврийн хэрэгсэл	122,239,012.85		-	122,239,012.85
Бусад үндсэн хөрөнгө	3,443,716.65		-	3,443,716.65
Дүн	284,076,086.40	4,111,818.18	-	288,187,904.58

(3) Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн данс дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

Хуримтлагдсан элэгдэл

2022 оны 12-р сарын 31

	01 сарын 01 -ний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	12 сарын 31-ний үлдэгдэл
Тавилга эд хогшил	36,858,340.16	9,300,751.32		46,159,091.48
Компьютер, дагалдах хэрэгсэл	63,902,736.70	3,725,202.30		67,627,939.00
Тээврийн хэрэгсэл	65,000,438.54	10,572,914.73		75,573,353.27
Бусад үндсэн хөрөнгө	1,354,650.32	344,151.43		1,698,801.75
Дүн	167,116,165.72	23,943,019.78	-	191,059,185.50

(Төгрөгөөр)

Хуримтлагдсан элэгдэл

2021 оны 12-р сарын 31

	01 сарын 01 -ний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	12 сарын 31-ний үлдэгдэл
Тавилга эд хогшил	27,557,588.84	9,300,751.32	-	36,858,340.16
Компьютер, дагалдах хэрэгсэл	57,960,121.65	5,942,615.05	-	63,902,736.70
Тээврийн хэрэгсэл	47,675,936.55	17,324,501.99	-	65,000,438.54
Бусад үндсэн хөрөнгө	1,010,498.89	344,151.43	-	1,354,650.32
Дүн	134,204,145.93	32,912,019.79	-	167,116,165.72

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

10. Биет бус хөрөнгө

(1) Биет бус хөрөнгө дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

Анхны өртөг

Хуримтлагдсан хорогдол

Биет бус хөрөнгийн дүн

	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
4,287,640.55	8,090,270.30	
3,732,263.61	3,802,629.75	
555,376.94	4,287,640.55	

11. Дансны болон бусад өглөг

Дансны болон бусад өглөг дараах үлдэгдэлээс бүрдэж байна:

(Төгрөгөөр)

Дансны өглөг

Төслийн санхүүжилтын өглөг

Дансны өглөгийн дүн

	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1,464,780,532.84	1,797,424,151.04	
1,464,780,532.84	1,797,424,151.04	

Бусад өглөг

Байгууллагад өгөх өглөг

Ажилчдад өгөх өглөг

Бусад өглөгийн дүн

Дансны болон бусад өглөгийн дүн

16,500.00	54,500.00
2,000.00	-
18,500.00	54,500.00
1,464,799,032.84	1,797,478,651.04

12. Татвар шимтгэлийн өглөг

Татвар шимтгэлийн өглөг дараах үлдэгдэлээс бүрдэж байна

(Төгрөгөөр)

ААНОАТ - ын өглөг

ХХОАТ - ын өглөг

НДШ - ийн өглөг

Татвар шимтгэлийн өглөгийн дүн

	2022 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
-	30,068.12	
122,000.00	4,157,986.75	
122,000.00	4,188,054.87	

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

13. Хувьцаат капитал

Компанийн эргэлтэнд буй нийт хувьцаат капитал нь нэг бүр нь 200,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Тус компанийн хувьцааг Монгол Улсын Хөгжлийн банк эзэмшиж байна.

(Төгрөгөөр)	Нийт хувьцааны тоо		Дүн	
	2022	2021	2022	2021
01-р сарын 01-нээр	50,000.00	50,000.00	10,000,000,000.00	10,000,000,000.00
Нэмж гаргасан				
Халаасны хувьцаа				
12-р сарын 31-нээр	50,000.00	50,000.00	10,000,000,000.00	10,000,000,000.00

14. Ерөнхий удирдлагын зардал

Тайлант жилүүдийн ерөнхий удирдлагын зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022	2021
Цалингийн зардал	197,957,124.21	477,705,541.85
НДШ-ийн зардал	24,728,231.42	61,500,992.98
Түрээсийн зардал	71,605,090.88	129,750,646.55
Элэгдлийн зардал	27,675,283.39	36,714,649.54
Засвар үйлчилгээний зардал	11,851,818.19	658,154.54
Мэргэжлийн үйлчилгээний зардал	3,532,800.00	4,019,059.09
Бичиг хэргийн зардал	2,520,972.63	652,314.50
Сургалтын зардал	3,724,827.73	3,532,681.32
Зар сурталчилгааны зардал	409,090.91	1,287,600.00
Шатахууны зардал	3,151,558.38	1,625,552.77
Бусад зардал	2,200,134.98	291,929.62
Тээврийн зардал	154,000.00	11,000.00
Хөдөлмөр хамгааллын зардал	224,954.54	-
Шуудан холбооны зардал	2,510,279.83	2,655,858.69
Ашиглалтын зардал	342,571.89	-
Даатгалын зардал	1,509,590.00	1,688,840.00
Төлбөр хураамжийн зардал	303,057.00	303,057.00
Ерөнхий удирдлагын зардлын дүн	354,401,385.98	722,397,878.45

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

15. Санхүүгийн орлого, зардал

(1) Тайлант жилийн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022	2021
Харилцахын хүүний орлого	-	1,317,015.40
Хадгаламжийн хүүний орлого	794,520.54	267,516,836.61
Бондын хүүгийн орлого	149,260,273.97	-
Санхүүгийн орлогын дүн	150,054,794.51	268,833,852.01

16. Бусад орлого, зардал

(1) Тайлант жилийн бусад орлогын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022	2021
Шатахууны картын урамшуулал	687,260.00	75,276,348.36
Бусад орлогын дүн	687,260.00	75,276,348.36

(2) Тайлант жилийн бусад зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022	2021
Найдваргүй авлагын зардал	380,068,498.87	-
Хандив тусlamж, тэтгэмжийн зардал	500,000.00	-
Гишүүнчлэлийн хураамж, төлбөр	500,000.00	750,000.00
Нүүлгэлтийн зардал	2,035,000.00	-
Алданги торгуулийн зардал	-	1,446,914.04
Бусад зардлын дүн	383,103,498.87	2,196,914.04

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

17. Орлогын татварын зардал

(1) Тайлант жилүүдийн орлогын татварын хөнгөлөлт дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022	2021
Орлогын албан татварын зардал	15,005,479.46	26,883,385.22
Хойшлогдсон татварын зардал (хөнгөлөлт)	-	-
Нийт орлогын татварын зардал, (хөнгөлөлт)	<u>15,005,479.46</u>	<u>26,883,385.22</u>

18. Нэгж хувьцаанд ногдох ашиг

Тайлант жилүүдийн нэгж хувьцаанд ногдох алдагдал дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	2022	2021
Тайлант үеийн ашиг, (алдагдал)	(601,768,309.80)	(407,367,977.34)
Эргэлтэнд гаргасан энгийн хувьцааны тоо	50,000.00	50,000.00
Нэгж хувьцаанд ногдох ашиг, (алдагдал)	<u>(12,035.37)</u>	<u>(8,147.36)</u>

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

19. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компанид дараах төрлийн эрсдэлүүд санхүүгийн хэрэглүүрээс үүдэн гарч байдаг

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл

Энэхүү тодруулга нь дээр дурдсан компанид учрах эрсдэл, компанийн эрсдэлийг хэмжихэд авч хэрэгжүүлж байгаа компанийн зорилго, бодлого болон үйл ажиллагаа мөн Компанийн капиталын удирдлагын тухай авч үздэг.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиromжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг удирдах болон хязгаарыг барихад чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон системийг зах зээлийн нөхцөл байдал болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа өөрчлөлтүүдийг тусгах үүднээс тогтмол хянаж байдаг. Компани нь ажилчдад тэдний үүрэг болон хариуцлагыг ухамсарлуулж чадахуйц дэг журamtай, үр дүнтэй хяналтын орчинг өөрийн сургалт болон удирдлагын стандарт, горимуудыг хэрэгжүүлэх замаар бий болгохыг зорж ажилладаг.

1) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлээгүйгээс компанийд санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд ихэнхдээ үйлчлүүлэгчдээс авах компанийн авлагаас үүсдэг.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдлийг илэрхийлж байдаг. Компанийн хамгийн их хүлээх зээлийн эрсдлийг санхүүгийн хөрөнгө тус бүрийн дансны үнээр илэрхийлэв:

(Төгрөгөөр)

	2022	2021
Харилцах дахь мөнгөн хөрөнгө	2,012,949,577.26	10,076,770,850.74
Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө	500,000,000.00	-
Өрийн үнэт цаас	6,810,000,000.00	-
Дансны болон бусад авлага	1,055,265,860.47	1,211,496,281.00
Дүн	<u>10,378,215,437.73</u>	<u>11,288,267,131.74</u>

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

19. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, Ургэлжлэл

Дансны болон бусад авлагууд

Компани үйлчлүүлэгчдийнхээ авлагуудыг төлөгдөх боломжтой авлага гэж үзэн хугацаа хэтэрсэн авлагуудад үнэ цэнийн бууралтын нөөц байгуулаагүй. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн өдрөөр дуусгавар болсон тайлант жилд данснаас хассан найдвартгүй авлага 211,123.1 мянган төгрөг байна.

Мөнгө болон түүнтэй адилтгах зүйлс

Компани 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,512,949.6 мянган төгрөгийн банкин дахь мөнгөн хөрөнгө (2021 онд: 10,076,770.8 мянган төгрөг)-тэй байсан. Компани олонд танигсан санхүүгийн байгууллагад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг байршуулах замаар зээлийн эрсдэлд өртөхийг хязгаарладаг. Компани нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлийн эрсдлийг оролцогч талуудын гадаад зээлийн үнэлгээнээс хамааруулан бага гэж үздэг.

2) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь компанийн орлого болон эзэмшиж байгаа санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэд нөлөөлж болох гадаад валютын ханш, хүүгийн түвшин гэх мэт зах зээлийн үнийн өөрчлөлтөд бий болох эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн эрсдлийн удирдлагын зорилго нь өгөөжийг оновчтой байлгах зуур зах зээлийн эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд удирдаж, хянах явдал юм.

(i) Гадаад валютын эрсдэл

Компанийн тайлагналын валют болох үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөс бусад валютаар хийгдсэн борлуулалт, худалдан авалт болон зээл нь гадаад валютын ханшийн эрсдлийг хүлээж байдаг.

19. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, Ургэлжлэл

Компанийн гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсээрх хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ дараах байдалтай байна:

(Төгрөгөөр)

	Гадаад валютаарх мөнгөн зүйлс			
	2022		2021	
	Америк доллар	Америк доллар	Төгрөг	Төгрөг
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	425,239.66	630,940.80	1,464,780,532.84	1,797,424,151.04
Дансны болон бусад авлага				
Дансны болон бусад өглөг	(425,239.66)	(630,940.80)	(1,464,780,532.84)	(1,797,424,151.04)
	—	—	—	—

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

19. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, Үргэлжлэл

Мэдрэмжийн шинжилгээ

Төгрөгийн ханш компанийн тайлант үеийн эцэст эзэмшиж буй бусад валютын ханшийн эсрэг 10 хувиар чангараход татварын дараах ашигт дараах байдлаар нөлөөлнө. Энэ шинжилгээ нь бусад бүх эрсдлийн хүчин зүйлсийг тогтмол гэж авч үзсэн болно.

(Төгрөгөөр)

	2022	2021
Татварын дараах ашиг дахь нөлөөлөл		

Бусад бүх хүчин зүйлсийг тогтмол гэж үзвэл төгрөгийн ханш компанийн тайлант үеийн эцэст эзэмшиж буй бусад валютын ханшийн эсрэг 10 хувиар сурхадад татварын дараах ашигт дээрхитэй ижил дүнгээр гэхдээ эсрэг байдлаар нөлөөлнө. Энэ шинжилгээ нь бусад бүх эрсдлийн хүчин зүйлсийг тогтмол гэж авч үзсэн болно.

(ii) Бодит үнэ цэнэ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр бүх санхүүгийн хэрэглүүрүүд дансны үнээрээ бүртгэгдсэн ба дансны үнэ нь бодит үнэ цэнэсээ материалыг зөрүүгүй байна.

Бодит үнэ цэнэ ба дансны үнэ

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон бодит үнэ цэнэ дараах байдалтай байна:

<i>(Төгрөгөөр)</i>	2022		2021	
	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ

Хорогдуулсан өргөөр бүртгэгдсэн хөрөнгүүд				
Дансны болон бусад авлагы	1,266,388,948.68	1,055,265,860.47	1,214,605,302.21	1,211,496,281.00
Бусад санхүүгийн хөрөнгө	7,160,000,000.00	7,160,000,000.00	-	-
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	2,163,134,396.10	2,163,134,396.10	10,077,796,463.80	10,077,796,463.80
	10,589,523,344.78	10,378,400,256.57	11,292,401,766.01	11,289,292,744.80

Хорогдуулсан өргөөр бүртгэгдсэн өр төлбөрүүд				
Дансны болон бусад өглөг	1,464,799,032.84	1,464,799,032.84	1,797,478,651.04	1,797,478,651.04
	1,464,799,032.84	1,464,799,032.84	1,797,478,651.04	1,797,478,651.04

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

19. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, Үргэлжлэл

(iii) Хүүгийн түвшний эрсдэл

Компанийн хүү тооцогдох санхүүгийн хөрөнгүүд нь ихэнхдээ тогтмол хүйтэй санхүүгийн хөрөнгүүд байгаа тул орлого болон үйл ажиллагааны мөнгөн урсгал нь зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтөд өртөх нь бага байдаг.

3) Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь санхүүгийн өр төлбөрөөс бий болох үүрэг хариуцлагыг мөнгө эсвэл бусад санхүүгийн хөрөнгөөр барагдуулахад компанийд учрах аливаа эрсдэлүүд юм.

Мөнгөн урсгалын хэлбэлзлийг бууруулах, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон санхүүгийн хэрэгслийн тоо хэмжээг тодорхойлох замаар компани хөрвөх чадварын эрсдлээ хянаж, удирддаг.

Компани нь аудитлагдсан санхүүгийн тайлан гарсан өдрөөс хойш 12 сарын хугацаанд компани ирээдүйд гарах гэрээний төлбөрүүд болон бизнесийн явцад үүсч байдаг өр төлбөрүүдийг төлөх хангалттай хэмжээний эргэлтийн болон капиталын хөрөнгөтэй гэж үзэж байгаа.

Капиталын удирдлага

Компани нь өр төлбөр болон өмчийг оновчтой зохицуулах замаар хувьцаа эзэмшигчдэд бий болох өгөөжийн түвшинг хамгийн их хэмжээнд байлгахын сацуу компанийн тасралтгүй үйл ажиллагааг хангах байдлаар капиталаа удирддаг.

(Төгрөгөөр)

	2022	2021
Нийт өр төлбөр	1,464,921,032.84	1,801,666,705.91
Нийт өмч	9,025,682,994.66	9,627,451,304.46
Өрийн харьцаа	16%	19%

20. Тайллагналын дараах үйл явц

Тайлант хугацааны эцсээс хойш компанийн санхүүгийн тайландаа тодруулагдах буюу залруулагдах материаллаг үйл явдал болоогүй.

21. Болзошгүй өр төлбөр

2022 оны 12 дугаар сарын 31-нээр бидэнд мэдэгдэж байгаа томоохон зарга маргаан, нэхэмжлэл үгүй байна. Өөрөөр хэлбэл байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрүүлэхүйц болзошгүй өр төлбөр байхгүй юм.

Ди Би Эм ассет менежмент УЦК ХХК
Санхүүгийн тайлангийн тодруулга

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

21. Болзошгүй өр төлбөр, Үргэлжлэл

(1) Хууль, эрх зүй

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад компанийд хуулийн арга хэмжээ авах болон гомдол хүлээн авах зэрэг асуудлууд тулгардаг. Ийм асуудлаас үүдэж болох компанийн хариуцлага нь компанийн санхүүгийн байдал болон ирээдүйн үйл ажиллагаанд материаллаг түвшинд сөргөөр нөлөөлөхгүй гэдэгт компанийн удирдлага итгэлтэй байна.

(2) Үүрэг хариуцлага

Компанид санхүүгийн тайлангийн өдрөөр санхүүгийн тайланд тодруулагдах буюу залруулагдах шаардлагатай болзошгүй өр төлбөр болон үүрэг хариуцлага байхгүй.